

**“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 24-ны өдөр

№ХЭХ 2024/..

Улаанбаатар хот

**“2023 оны компанийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
гаргасан дүгнэлтийг батлах тухай”**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7.6.9 дахь заалт, Тооллогын комиссын дүгнэлтийг тус тус үндэслэн,

ТОГТООХ НЬ:

1. “СОР” ХК-ийн 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



УЛААНБААТАР ХОТ
“СОР” ХК-ийн
ҮСЛЭГ ЭДЛЭЛИЙН

Б.АМАРСАНАА

**“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 24-ны өдөр

№ХЭХ 2024/02

Улаанбаатар хот

[Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай]

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсгийг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “СОР” ХК-ийн дүрмийн холбогдох заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулж нэгдүгээр дүгээр Хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэн, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ц.Чулуунчимэг-г үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.АМАРСАНАА



“СОР” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1/ Компанийн дүрмийн 7.2 дахь заалтад дараах өөрчлөлт оруулах :

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2/Компанийн дүрмийн 7.10, 7.11 дэх заалтад:

7.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгох ба кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.

7.11.Хувьцаа эзэмшигч нь энэ дүрмийн 7.10-т заасан саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй

3/ 7.21-р зүйлийн 1, 2, 3 дах заалтуудыг хасах

4/ 7.23-р зүйлийн 3, 5 дах заалтад өөрчлөлт оруулах. Үүнд:

- “5” жил гэснийг “3” жил гэж өөрчлөх

- “сонгуульт ажлууд” гэснийг хасах

-7.23-р зүйлийн 7, 8 дах заалтуудыг хасах

5/ 7.34-р зүйлд :“Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ний гишүүд санал нэгтэй гаргана.” Гэснийг хасах.

6/ 7.36 заалтыг бүхэлд нь хасах

7/ 7.40-р зүйлийн 3 дах заалтыг бүхэлд нь хасах

8/ 8.1 заалтад “ТУЗ-ийн нарийн бичгийн дарга”, “Санхүү хариуцсан захирал” гэсэн албан тушаалтнуудыг нэмэх

9/ 8.3 заалтыг бүхэлд нь хасах

10/ 9.12 заалтыг бүхэлд нь хасах

11/ 10.4 заалтыг дараах байдлаар өөрчлөх: Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр “эсхүл цахимаар” мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.”

12/ 12-р зүйлийг бүхэлд нь хасах

**“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 24-ны өдөр

№ХЭХ 2024/03

Улаанбаатар хот

**ГТөлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг томилж тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалт, Тооллогын комиссын дүгнэлтийг тус тус үндэслэн,

ТОГТООХ НЬ:

1. Доорх нэр бүхий хүмүүсийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд сонгосугай.

ЕРДИЙН гишүүнээр:

1. Д.Нямхүү
2. И.Дариймаа
3. Б.Амарсанаа
4. Л.Таня
5. Н.Ю.Огай
6. Пономаревна Светлана

ХАРААТ БУС гишүүнээр

1. Ө.Жамбалсүрэн
2. Д.Жанрай
3. С.Б.Громов

2. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэхийг ТУЗ-ийн гишүүдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА

**“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 24-ны өдөр

№ХЭХ 2024/04.

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62 дугаар зүйлийн 62.1.16, Компанийн дүрмийн 7.6.13, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг 9,0 / есөн сая / төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА